

Дэлгэрцогт сумын Цахиурт багийн Засаг дарга
Г.Сосорбурамын 2018онд хийсэн ажлын тайлан.

2019.01.04

Амардалай

Багийн эрх ашигт нийцүүлэн гаргасан МУ-ын хууль тогтоомж,ЗГ-ын бодлого, шийдвэр, Аймаг,сумын засаг дарга нарын мөрийн хөтөлбөр,аймаг сумын И.Т.Хурлын гаргасан тогтоол,шийдвэрийг үйл ажилгаандаа мөрдлөгө болгон,төрийн үйлчилгээг ард иргэд болон,малчдад хөнгөн шуурхай хүргэх ажилд гол анхаарлаа тавин ажиллаж ирлээ.

Багийн засаг даргад иргэдээс тавьсан санал хүсэлт,өргөдөл гомдолыг хүлээн авч цаг хугацаанд нь ямар нэгэн чирэгдэлгүй хөнгөн шуурхай ,үнэн зөв шийдвэрлэж ирлээ.Тайлангийн хугацаанд санал хүсэлт 39,өргөдөл 17-ыг хүлээн авч 158 албан тоот үйлдэн шийдвэрлээд байна.

-Аймгийн сайн малчинаар шалгаруулахаар Цахиурт багийн Сумын сайн малчин О.Батсайханы материалыг журамд заасны дагуу бүрдүүлэн Аймгийн хөгжлийн бодлогын хэлтэст явуулсан болно.

- Дундговь аймгийн зүүн талын сумдаар малын гоц халдварт Шүлхий өвчин гарсантай холбогдуулан 01-р сарын 05-ны өдрөөс эхэлэн 21 хоногийн хугацаатай өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан малын хариуллага маллалгааг сайжруулах,өвчний сэжиг илэрвэл нэн даруй мэдэгдэх,энэ өвчний талаар малчдад мэдээлэл өгөх,гарын авлага материалиар хангах,айл өрхөөрөө явах зэрэг ажлыг хийлээ.

-Аймгийн З.Д.Т.Газраас Хяналт шинжилгээ үнэлгээний баг ирж тус суманд 2 өдөр ажиллаад явсан.Тус шалгалтаар хэвийн ажилгаатай гэсэн үнэлгээ авлаа.

-Жил бүрийн Хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө 9-н алдартаа шалгаруулдаг уламжлал,ёсоор алдартанд тодорхойлж байгаа хүмүүсийнхээ ажил байдлын тодорхойлолтыг Засаг даргын зөвлөлөөр хэлцүүлэхээр ЗД-ын орлогч З.Наранмандахад гарган өгч ажиллаа.

-Сумын Н.Д.Байцаагчид 2018,2019 онд өндөр настны тэтгэвэрт гарах иргэдийн судалгаа гарган өгсөн болно.

-Тус багийн төв Цахиурт гэдэг Төв аймгийн Бүрэн,Баян-Өнжүүл сумаас отроор ирж өвөлжөөд буцаж явсан малчин Мөнхбаатар,Батсайхан нарын үхэр сүрэгт малын гоц халдварт Шүлхий өвчин гарсан тул Сумын засан даргын 2018 оны

02-р сарын 07-ны өдрийн А\13 тоот захирамж гарч Хорио цээрийн дэглэм тогтоосон байна. 2-р сарын 06-09 хооронд шүлхий өвчин гарсан өрхүүдийн өвчилсөн үхрийг устгах устгалын ажилд хяналт тавих ажлын хэсэгт томилогдон гурав хоног ажиллаж, Дэрэн сумын устгалын цэг болох Дэрэн, Баянцагаан сумын зааг нутаг Улаан хад гэдэг газар өвчтэй 35 үхрийг устгалаа. 2-р сарын 12-ны өдрөөс эхлэн Цахиурт багийн нутаг Энгэрийн шанд гэдэг газар хяналтын Постонд хөдөлгөөнт эргүүлийн үүрэгийг гүйцэтгэн ажиллаа.

-Постонд ажиллах хугацаандаа:

Ё.Нэргүй, Н.Батбаяр, П.Батмягмар, Л.Батбаатар, Ц.Адъяадорж, Н.Батбаяр, Б.Балжинням, нарын хүмүүстэй хамтран үүрэг гүйцэтгэлээ.

-Номтын энгэрийн пост, Цэнхэр худгийн пост, мөн хяналтын бүсээр өөрийн хувийн машин болох 75-57Убу дугаартай Соната-2 авто машинаар явж, постуудад хяналт тавих хяналтын бүсэд ойртож ирсэн малыг хөөх, дайран өнгөрч байгаа машин техникийг голомтын бүсрүү нэвтрүүлэхгүй байх, ариутгал хийх зэрэг ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Цэнхэр худгийн постон дээр машин ариутгах пункт барилцаж, Харуултын ар гэдэг газар устгалын нүх ухах цэгийг тогтоох тэнд нүх ухахаар ирж байгаа машин техникт зам зааж өгөх, зэрэг ажлыг давхар гүйцэтгэн ажиллаа.

-Харуултын арын устгалын цэгт 59 үхэр, эзэнгүй 2 хонь, 1 ямаа бүгд 62 малыг устгалд орууллаа. Мөн ойр орчмын үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх ажилд оролцож 14 адуу, 1 үхрийг сэгийг устгалын нүхэнд хийж ойр орчмийг нь цэвэрлээд байна.

-Энгэрийн шандны постонд ажиллаж байх хугацаандаа давхардсан тоогоор 29 авто машиныг ариутгаж, 17 авто машиныг голомтын бүсрүү оруулалгүй тойруулж, 36 мотоциклийг ариутгаж халдваргүйжүүллээ.

-2-р сарын 16-ны өдөр тус багийн иргэн Ц.Баатар, Адаацаг сумын үл таних 1 хүнтэй хамт согтуугаараа айл хэсч хяналтын бүсэд явж байсныг саатуулан зохих газарт нь хүргэн өгч, өвчин тархахаас урьдчилан сэргийлж хуулийн дагуу арга хэмжээ авхуулж ажиллаа.

-Постонд ажиллах хугацаандаа 200 гаруй литер бензин, 1л тос, зарцуулж, нийт 1374км газар явж, хөдөлгөөнт эргүүлийн ажлыг гүйцэтгэсэн байна.

-3-р сарын 03-нд голомтын бүсрүү зөвшөөрөл өгсний дагуу орж малчин Батсайхантай биечлэн уулзаж торгуулийн мөнгөө даруй төлөх, сэг зэм устгалын

зардал 80,0 төгрөг зэргийг нэхэмжилж,ойр орчмынхоо үхрийн баас,хөлдүүш,хөлдсөн шээс зэргийг нь цэвэрлэхийг шаардаж,бөөгнүүлж шатаах талаар санал болгож зөвөлгөө өгч ажиллаа.

-2018 оны 3-р сарын 05-нд Энгэрийн шандны постыг буулгаж,Цэнхэр худгийн поструу шилжин ирж Б.Балжинням,Р.Давгажамц зэрэг хүмүүстэй хамтран ажиллаж, Адаацаг сумын малчин Бүдсүрэн,Сэргэлэн сумын малчин Д.Баттөр нарын адууг отроос бууж яваа замд нь тосч хаагуур тууж өнгөрөх замыг нь зааж өгч,аль болох хужир мараа ихтэй газраар,явж өнгөрхийг зөвөллөө.Мөн Баруун буурал дамнаад үхэр туусан хүн явчихлаа гэсэн мэдээллийг хүлээн авснаар,хаанаас яваа аль сумын хэн гэдэг айлын үхэр болох вакцинд хаана хамрагдсан зэрэг асуудлыг асууж тодруулхаар тосч уулзан,Баян-Өнжүүл сумын малчин Батцэнгэл гэдэг хүн явж байсныг олж тогтоолоо.Тэр айл Өндөршил суманд отроор өвөлжөөд буцаж байгаа юм байна.1-р сарын 04-нд Өндөршил сумын малын эмчээр үхэртээ вакцин хийлгэсэн,өвчин гарсан газраас зайдуу газар нутаглаж байсан айл юм байна.Үүдийн булгийн хужир дамнаад буцахыг зөвөллөө.

-Сумын засаг даргын 03-р сарын 09 ны өдрийн А\18 тоот Хорио цээрийн дэглэмийг цуцалж,Хязгаарлалтын бүс тогтоох тухай Сумын засаг даргын захирамж Iгарсанаар 14 хоногийн хугацаанд,хязгаарлалтын бүсэд шилжин ажиллаа.Хязгаарлалтын бүс тогтоосон хугацаа дуусч постууд бүр мөсөн бууснаар, малчдыг сонор сэрэмжтэй байж,малынхаа харицлга малалгаанд анхаарч ажиллахыг зөвөллөө.

-Хугацаат мэдээ тайлангуудыг хугацаанд нь гарган өгч ажиллаа.Одоогийн байдлаар тус багт 24541эх мал төлөл .20987 төл хүлээн аваад байна. Мөн 3554.төл хорогдож 2267. том мал хорогдоод байна.

- 4-р сарын 09-10 ныг дуустал аймагт “Хамтарсан багийн гишүүдийг чадвахжуулах нь Сайнцагаан, Дэлгэрхангай сумдтай хамтарсан бүсчилсэн сургалтанд,Хэсгийн төлөөлөгч,Хүн эмнэлгийн эрхлэгч,Сургуулийн нийгмийн ажилтан, Засаг дарга, Багийн дарга нартай хамт оролцож, өөрийн мэдлэг чадвараа дээшлүүллээ

-Тус суманд Авто техникийн улсын үзлэг болж өнгөрсөн.Иргэдэд зарлан мэдээлэх ажлыг сайн хийсний үр дүнд,иргэд машин тэрэг, мотоциклио үзлэгт сайн хамруулж ажиллаа.

- Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх тандалт судалгааны багийн хүмүүст багийнхаа аль их огтонотой газрыг танилцуулж зураглал гарган өгч ажиллаа.

- Багийн хүний эмч Нямдуламтай хамтран багийн айл өрхөөрөө явж,төл,бойжилт хорогдлын мэдээ авч,тэдэнд төрийн болон,хүн эмнэлгийн үйлчилгээг үзүүлж,тэдний санал бодлыг сонсож ажиллаа.Айл өрхөөр явахад багийн малчин өрхийн 80 орчим хувь нь нүүгээд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын урд заагаар бууцгаасан байна.Ус ховор айл мал олон малын хаваржилт хүндхэн байлаа.

- Мод услах,дэлгүүрийн урд саадны элсийг цэвэрлэх,зүүн хойд лагерийн ундны усны худгийн хашааг сэргээн засварлах, зэрэг нийтийг хамарсан ажилд өөрийн биеэр биечлэн оролцож ажиллаа.

- Цахиурт багийн Б.И.Н.Х –ын тэргүүлэгч нарыг хуралдуулан улсын хөрөнгө оруулалтаар гаргах нэг худгийг хэлцүүлж “Моломын ухаа” гэдэг газар гархуулхаар шийдвэрлүүлээ.

- Хий харын бууцны урд дээрэээс, Зүүн шанд хүртэл 72 км газар,тус сумын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч байгаа өндөр хүчдэлийн агаарын шугамын дагуу явж координатыг нь тогтоох, ажлын хэсэгт орж ажиллаа.

- 5-р сарын 09-11 ны хооронд Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготонотой тэмцэх, ажлын хэсгийн бие бүрэлдхүүнтэй хамтран Тал булгийн эхээс эхлэн,Дэлгэр нуур,Далай ээжийн Баян хошуу орчмоор, мөн Хоолой худаг,Баянгийн булаг,Булшт,Хаяа орчмыг нутгийг хамарч микро биологийн болон энгийн механик аргаар үлийн цагаан оготонотой тэмцэх,хордуулсан будаа 1,4 тонныг цацаж утагч 4 багажаар утах ажлыг хийж гүйцэтгэлээ.Уг ажилд 2 мотоцикл, 1 авто машин 8 хүн амжилттай сайн ажиллаа.



- Багийн нутаг дэвсгэр байгаа эзэнтэй болон,эзэнгүй уруудаж ирээд үхсэн малын сэг зэмийг мотоцикльтой явж өөрийн биеэр тоолж ирсэн болно.

- Ингээд 5-р сарын16-20 ныг хүртэл 2 машин,1 мотоцикль, 4 хүний бүрэлдхүүнтэй явж үхсэн малын сэг зэмийг устгах ажлыг бүтэн 5 өдрийн турш амжилттай хийж дуусгалаа.Сумын төвийн Хөх овооны хогийн цэгийн устгалын нүх болон,Шугамын хөхийн устгалын нүхэнд -167 бод малын,478 бог малын болон 1үнэг,1зээрийн,нийт 647 сэг зэмийг булж устгалаа.



- 5-р сарын 26 нд тус сумын малчдын дунд “Малчид дуулж байна” дууны уралдаан амжилттай болж өндөрллөө.Тус тэмцээнд манай багийн залуу малчин С.Ишдорж амжилттай оролцон тэргүүн дэд байр эзэллээ.

- 40-60 насны хоорондын идэр настнуудын анх дугаар чуулган амжилттай боллоо.Энэ удаагийн чуулганд отор нүүлдэл,цаг агаарын байдлаас болж малчид маань төдийлөн сайн оролцож чадаагүй болно.Оролцсон иргэд маань сэтгэл хангалуун, баяртай байлаа

-ХАӨМСанд байгаа алдааг нэг бүрчлэн засаж залруулан,шинээр төрсөн хүүхэд,шилжилт хөдөлгөөн, нас баралт,шилжилт хүлээгдэж байгаа болон,шилжилт баталгаажуулах хүн, зэрэг бүх алдааг засч аймгийн Статистикын хэлтэстэй хамтран ажиллаж байна.

- 2018 оны 06-р сарын 02 ны өдөр Сумын онцгой комиссын нарийн бичгийн дарга С.Нарантунгалагтай хамтран Цахиурт багийн төв дээр зусч байсан тус багийн малчин Ц.Жамсранжавын нэг гэр хүчтэй салхинд ойчсоныг газар дээр нь очиж нүдээр үзэж зураг хөргий нь авч эвдрэл гэмтлийг нь тогтоож Аймгийн онцгой комисст мэдэгдсэн болно.

- Сумын соёлын төв нь гэр бүлийн сарын ажлын хүрээнд,иргэдийн санал хүсэлтийн дагуу зохион байгуулсан “Ачлалт ээж” “Дархан бэр” шалгаруулан алдаршуулах ажилгаанд багийнхаа 7-н ээжийн материалыг бүрдүүлэн өгч шагнууллаа.

- 18-40 насны залуучуудын чуулга уулзалтын зарыг хүргэх,тэдгээрийг идэвхитэй оролцуулах ажилд онцгой анхаарал тавин ажиллаа.Чуулганы үеэр “Монгол уламжлалт”олон төрөлт тэмцээн болж багийн залуучууд маань ирц сайтай,идэвхитэй сайн оролцлоо.Хос морьтон шалгаруулах,морин дээрээс 4 бэрх шүүрэх,морин поло,дэмбээ,айраг уух, хуруу барих наадгай,шагайгаар наадах, зэрэг төрөл бүрийн тэмцээн наадам болж залуучууд маань авхаалж самбаагаа сорьж нэгэн өдрийн инээд,наргиантай хөгжилдөн тэмцэлдэж өнгөрөөлөө.Чуулганд оролцсон залуучуудын хоолонд зориулж,тус багийн малчин Б.Туваан,С.Гантөгс нар тус бүр нэг,нэг ямаагаар ивээн тэтгэлээ.

-Өвөлжөө хаваржааныхаа кадастрын зурагаа авхуулаагүй айл өрхийн хороо бууцны зургийг авхуулах ажлаар 1-р багийн засаг дарга П.Мөнхзоригтой хамт явж 18-н хорооны зургийг авхуулж эзэнд нь олгох ажлыг хийж гүйцэтгэлээ.

- 2018 оны намрын ээлжит цэрэг татлаганд хамрагдах 23-н цэрэг эрсийн зарлан дуудах хуудасыг хүлээн авч,эзэнд нь биечлэн хүргэн өгч ажиллаа.Тус багаас 21 цэргийн насны залуучууд хамрагдсанаас О.Сандагдорж цэргийн жинхэнэ албанд тэнцэж одоо албаа нэр төртэй сайн хааж байна.Цэрэг татлагын үеэр төрөл бүрийн хуулийн сургалт,залуучуудын дунд сагсан бөмбөг,караоке дууны тэмцээн амжилттай болж өндөрллөө.

-Багийн нийт иргэдэд хууль эрх зүй,нийгмийн эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулах,иргэдээс гарч байгаа санал хүсэлтийг сонсох,хүлээн авах,тэдний нийгмийн идэвхи,оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан багуудын нэгдсэн өдөрлөгийн арга хэмжээнд иргэд идэвхитэй сайн оролцлоо.

- Сумын И.Т.Х-ын тэргүүлэгчдийн дарга П.Цолмонбаатар,багийн эмч Нямдулам,татварын байцаагч Б.Санжаасүрэн,жолооч Ж.Баярсайхан,Багийн засаг дарга миний бие,Сумын засаг даргын захирамжаар мал тооллогын комисст томилогдон 2018 оны жилийн эцсийн мал тооллогыг багтаа амжилттай зохион байгууллаа.Манай баг нийт 70214 толгой мал тоолуулж,шинээр малчин Д.Мөнхбаатар,Э.Намжилдорж,Ц.Цэсэм нар 1000-аас дээш мал тоолуулж мянгат малчин боллоо.2018 оны жилийн эцсийн байдлаар манай баг 26451 эх мал төллөж,17024 төл бойжуулж 9432 төл хорогдсон мэдээ гараад байна.Мал өмнөх

оныхоосоо 5-н төрөл дээрээ буурсан үзүүлэлттэй байна.Жилийн эцсийн хүн амаа
ХАӨМСангийн программ дээр шилжилт хөдөлгөөнөө цэгцэлэн янзалж байна

Тайлан бичсэн Багийн засаг дарга

Г.Сосорбурам